ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## БУЛГАН ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Аудитын код: ХОА-2021/117/СТА-ТШЗ**


Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061
Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545
Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Мөнхтулга
Утас: 70432545
цахим хаяг: munkhtulga.d@audit.gov.mn


Цахим хуудас: www.audit.mn

Ховд хот

2021 он

*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.*

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| *АДБОУС* | *Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт* |
| *АОУС* | *Аудитын Олон Улсын Стандарт* |
| *УСНББОУС* | *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт* |
| *ТТЗ* | *Төсвийн төвлөрүүлэн захирагч* |
| *ТШЗ* | *Төсвийн шууд захирагч* |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....**Error! Bookmark not defined.**
3. Аудитын тайлан....8
3.1. Ерөнхий зүйл....8
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ....9
3.4. Материаллаг байдал ....9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....9
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....11
3.7. Шилэн дансны мэдээлэл ....11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....12
3.9. Аудитын илрүүлэлт....12
Залруулсан алдаа....12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .. **Error! Bookmark not defined.**
Аудитын зөвлөмж....12
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ....12
4. Менежментийн захидал....12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....13

# 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021.02.06 № 2/32
танай ________ -ны № ________ -т

БУЛГАН ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН ДАРГА О.ЛХАГВА-ЭРДЭНЭ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган дахь гаалийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Булган дахь гаалийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Булган дахь гаалийн газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

021020239

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **96,253,298.31** | **72,393,400.81** |
| **33** | **АВЛАГА** | 27,131,587.00 | - |
| **335** | **Бусад авлага** | 27,131,587.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 27,131,587.00 | - |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 357,850.00 | - |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 357,850.00 | - |
| 34714 | Томилолтын урьдчилгаа | 357,850.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 68,763,861.31 | 72,393,400.81 |
| **354** | **Хангамжийн материал** | 55,065,861.48 | 57,535,400.98 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,154,066.00 | 2,855,266.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,199,962.00 | 1,823,962.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 16,283,500.00 | 9,250,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 35,428,333.48 | 43,605,672.98 |
| 35600 | Мал амьтад | 13,697,999.83 | 14,857,999.83 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,391,271,817.90** | **2,693,725,667.86** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,391,271,817.90 | 2,693,725,667.86 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,388,352,817.90 | 2,639,588,031.86 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,643,427,329.80 | 2,654,677,329.80 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (413,904,130.30) | (481,400,629.78) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 208,265,000.00 | 208,265,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (154,943,334.00) | (167,265,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 465,020,789.48 | 796,902,084.22 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (359,577,580.08) | (374,790,752.38) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 28,692,820.00 | 30,872,040.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (28,628,077.00) | (27,672,040.00) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 2,919,000.00 | 54,137,636.00 |
| 39301 | Програм хангамж | 1,685,872.11 | 1,685,872.11 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,685,872.11) | (1,685,872.11) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,919,000.00 | 54,137,636.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,487,525,116.21** | **2,766,119,068.67** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,487,525,116.21** | **2,766,119,068.67** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,487,525,116.21 | 2,766,119,068.67 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,633,192,809.65 | 2,633,192,809.65 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,633,192,809.65 | 2,633,192,809.65 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (213,194,727.48) | 65,399,224.98 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (213,194,727.48) | (213,194,727.48) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 278,593,952.46 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 67,527,034.04 | 67,527,034.04 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,487,525,116.21** | **2,766,119,068.67** |

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **741,396,964.00** | **1,122,829,254.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **23,579,412.00** | **424,332,654.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 23,579,412.00 | 424,332,654.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 15,618,000.00 | 422,940,354.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,618,000.00 | 10,640,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 412,299,854.00 |
| 120005 | Түрээсийн орлого | 1,624,350.00 | 1,392,300.00 |
| 120009 | Бусад орлого | 6,337,062.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **717,817,552.00** | **698,496,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 646,991,800.00 | 698,496,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 646,991,800.00 | 698,496,600.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 70,825,752.00 | - |
| 133003 | Хөрөнгийн | 70,825,752.00 | |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **739,093,258.21** | **837,454,801.54** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **739,093,258.21** | **837,454,801.54** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 729,448,646.11 | 835,068,400.02 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 439,065,461.78 | 492,890,540.46 |
| 210101 | Үндсэн цалин | 427,228,461.78 | 479,006,540.46 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11,837,000.00 | 13,884,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 55,824,383.32 | 63,210,145.02 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,362,741.65 | 43,547,561.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,382,355.29 | 5,202,892.44 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,505,884.05 | 3,961,212.53 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 870,309.17 | 954,407.23 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,703,093.16 | 9,544,071.24 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 80,436,458.00 | 109,254,187.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 28,410,568.00 | 39,500,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 50,170,284.00 | 68,455,737.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,855,606.00 | 1,298,450.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,611,926.00 | 15,817,060.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,693,060.00 | 2,620,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,798,461.00 | 10,541,490.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,331,820.00 | 1,515,670.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 246,000.00 | 168,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 542,585.00 | 971,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,754,003.80 | 15,314,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,863,961.00 | 2,719,550.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,230,887.00 | 5,074,320.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,659,155.80 | 7,520,230.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,581,150.00 | 3,500,050.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,581,150.00 | 3,500,050.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,005,962.28 | 13,046,859.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,694,299.00 | 6,593,460.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 150,000.00 | 432,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,234,706.00 | 2,524,334.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 194,725.00 | 184,725.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | 99,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 200,000.00 | 150,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 60,000.00 | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 7,373,232.28 | 3,063,340.50 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 110,169,300.93 | 122,035,458.04 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 210,500.00 | 128,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 109,958,800.93 | 121,907,458.04 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 9,644,612.10 | 2,386,401.52 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 9,644,612.10 | 2,386,401.52 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,644,612.10 | 2,386,401.52 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **2,303,705.79** | **285,374,452.46** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 22,781,603.18 | 6,780,500.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 11,972,498.54 | |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 10,809,104.64 | 6,780,500.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (22,781,603.18) | (6,780,500.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(20,477,897.39)** | **278,593,952.46** |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **655,939,672.00** | **703,457,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **8,947,872.00** | **4,961,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 8,947,872.00 | 4,961,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 6,627,372.00 | 2,700,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,627,372.00 | 2,700,000.00 |
| 120005 | Түрээсийн орлого | 2,320,500.00 | 2,261,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **646,991,800.00** | **698,496,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 646,991,800.00 | 698,496,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 646,991,800.00 | 698,496,600.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **655,939,672.00** | **703,457,600.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **655,939,672.00** | **703,457,600.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **646,295,059.90** | **700,202,498.48** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 441,598,510.10 | 490,363,285.48 |
| 210101 | Үндсэн цалин | 264,351,014.73 | 269,661,599.50 |
| 210102 | Нэмэгдэл | 134,335,495.37 | 154,226,399.98 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11,841,000.00 | 14,575,286.00 |
| 210104 | Урамшуулал | 31,071,000.00 | 51,900,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 53,786,300.00 | 65,722,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,373,100.00 | 48,171,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,103,300.00 | 4,387,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,282,600.00 | 3,510,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 820,700.00 | 877,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,206,600.00 | 8,775,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 90,492,200.00 | 91,053,764.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 36,500,000.00 | 39,500,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 52,134,900.00 | 50,253,714.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,857,300.00 | 1,300,050.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,847,916.00 | 16,282,960.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,928,500.00 | 2,706,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,798,996.00 | 10,759,990.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,331,820.00 | 1,610,670.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 245,600.00 | 219,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 543,000.00 | 986,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 31,579,618.80 | 21,804,570.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,300,000.00 | 7,919,770.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,279,618.80 | 6,144,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 24,000,000.00 | 7,740,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,939,000.00 | 3,142,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,939,000.00 | 3,142,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,833,915.00 | 11,635,319.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,895,484.00 | 6,593,460.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 150,000.00 | 432,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,234,706.00 | 2,524,334.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 194,725.00 | 184,725.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | 99,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 200,000.00 | 178,900.00 |
| 210807 | Газрын төлбөр | 60,000.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,000,000.00 | 1,622,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 217,600.00 | 198,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 217,600.00 | 198,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **9,644,612.10** | **3,255,101.52** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 868,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 868,700.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 9,644,612.10 | 2,386,401.52 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,644,612.10 | 2,386,401.52 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 2,633,192,809.65 | 67,527,034.04 | -192,716,830.09 | 2,508,003,013.60 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,633,192,809.65** | **67,527,034.04** | **-192,716,830.09** | 2,508,003,013.60 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | -20,477,897.39 | -20,477,897.39 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,633,192,809.65** | **67,527,034.04** | **-213,194,727.48** | 2,487,525,116.21 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,633,192,809.65** | **67,527,034.04** | **-213,194,727.48** | 2,487,525,116.21 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,633,192,809.65** | **67,527,034.04** | **-213,194,727.48** | 2,487,525,116.21 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 278,593,952.46 | 278,593,952.46 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,633,192,809.65** | **67,527,034.04** | **65,399,224.98** | 2,766,119,068.67 |

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 704,496,600.00 | 700,202,498.48 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 704,496,600.00 | 700,202,498.48 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 704,496,600.00 | 700,202,498.48 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 490,676,500.00 | 490,363,285.48 |
| 210101 | Үндсэн цалин | 269,661,600.00 | 269,661,599.50 |
| 210102 | Нэмэгдэл | 154,226,400.00 | 154,226,399.98 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,888,500.00 | 14,575,286.00 |
| 210104 | Урамшуулал | 51,900,000.00 | 51,900,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 65,722,400.00 | 65,722,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,171,300.00 | 48,171,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,387,800.00 | 4,387,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,510,200.00 | 3,510,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 877,600.00 | 877,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,775,500.00 | 8,775,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 93,534,900.00 | 91,053,764.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 39,500,000.00 | 39,500,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 52,134,900.00 | 50,253,714.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,900,000.00 | 1,300,050.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,514,200.00 | 16,282,960.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,725,400.00 | 2,706,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,770,300.00 | 10,759,990.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,812,900.00 | 1,610,670.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 219,400.00 | 219,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 986,200.00 | 986,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 21,853,800.00 | 21,804,570.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,968,900.00 | 7,919,770.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 6,144,900.00 | 6,144,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,740,000.00 | 7,740,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,142,200.00 | 3,142,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,142,200.00 | 3,142,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,854,500.00 | 11,635,319.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,243,800.00 | 6,593,460.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 582,000.00 | 432,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,526,900.00 | 2,524,334.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 240,800.00 | 184,725.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 100,000.00 | 99,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 179,100.00 | 178,900.00 |
| 210807 | Газрын төлбөр | 192,000.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,789,900.00 | 1,622,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 198,100.00 | 198,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 198,100.00 | 198,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 704,496,600.00 | 700,202,498.48 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 698,496,600.00 | 696,760,538.48 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 698,496,600.00 | 696,760,538.48 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 6,000,000.00 | 3,441,960.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,000,000.00 | 3,441,960.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 41 | 35 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 24 | 18 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16 | 16 |

# 3.АУДИТЫН ТАЙЛАН

## 3.1. Ерөнхий зүйл

Булган дахь гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга О.Лхагва-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч программ хангамжийн ашиглалтын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 01-нээс 2021 оны 02 дугаар сарын 05–ний хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхтулга хариуцаж хэрэгжүүлэв.

## 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

*Ховд аймгийн Булган дахь гаалийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь: Улсын хилээр бусаар бараа тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх, Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах, Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх, Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх гэсэн зорилт тавин ажилласан байна.*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай"*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот ''бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай''*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот ''Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

## 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Булган дахь гаалийн газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ховд аймгийн Булган дахь гаалийн газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Unicus" программ хангамж ашигладаг байна.

Булган дахь Гаалийн газарт 2020 онд Гаалийн ерөнхий газрын яамны санхүүгийн дотоод хяналт шалгалт ороогүй болно.

Гаалийн ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 741396.9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 7413.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын 1122829.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 11228.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Булган дахь гаалийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 278593.96 мянган төгрөгөөр буюу 11 хувиар

өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Тайлангийн үзүүлэлтүүд | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| Авлага | 27,489.43 | 0.00 | -27,489.43 | -100% |
| Бараа материал | 68,763.86 | 72,393.40 | 3,629.54 | 5% |
| Үндсэн хөрөнгө | 2,391,271.81 | 2,693,725.66 | 302,453.85 | 13% |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,487,525.10** | **2,766,119.06** | **278,593.96** | **11%** |
| **Богино хугацаат өр төлбөр** | | | 0.00 | **0%** |
| Цэвэр хөрөнгө, өмч | 2,487,525.10 | 2,766,119.06 | 278,593.96 | 11% |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,487,525.10** | **2,766,119.06** | 278,593.96 | **11%** |

Авлага дансны үлдэгдэлгүй болж 27489.43 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны уурын зуухны авлага 16181.1 мянган төгрөг, цахилгааны төлбөрийн авлага 10950.48 мянган төгрөг, томилолтын авлага 357.85 мянган төгрөгийг тайлант онд буурсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 72393.40 мянган төгрөг болж 3629.54 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд Гаалийн ерөнхий газраас үнэ төлбөргүй 10119.51 мянган төгрөгийн бараа материал нийлүүлсэн, мөн тайлант оны эхний үлдэгдлээс үйл ажиллагаандаа зарцуулсан зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 2391274,81 мянган төгрөг, оны эцэст 2693725.66 мянган төгрөгөөр болж 302453.85 мянган төгрөгөөр өссөн байна .

Үндсэн хөрөнгийн данс нь Гаалийн ерөнхий газраас тайлант онд 402180.34 мянган төгрөгийн хөрөнгө нийлүүлсэн, төсвийн хөрөнгөөр 5999,99 мянган төгрөгийн хөрөнгө авч авлагаас 16181.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, Гаалийн ерөнхий газрын зөвшөөрлөөр 27832.15 мянган төгрөгийн хөрөнгө акталж тайлант оны элэгдлийн зардал 121907,46 мянган төгрөг байгаагаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2766119.06 мянган төгрөг болж тайлант онд 278593.96 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь тайлант оны үр дүн 278593.96 мянган төгрөг байгаатай холбоотой байна.

Булган дахь Гаалийн газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 381432.3 мянган төгрөгөөр буюу 51 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 381432.3 мянган төгрөгийн орлогоос 412299.85 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого, 51504.8 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгийн санхүүжилтийн орлого 70825.75 мянган төгрөг, түрээсийн орлого 232.05 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 4977.5 мянган төгрөг, бусад орлого 6337.06 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 47517.92 мянган төгрөгөөр буюу 7.2 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 60700.87 мянган төгрөг буюу 12.4 хувиар, тогтмол зардал 561.6 мянган төгрөг буюу 0.6 хувиар, хангамж бараа материалын зардал 2435.0 мянган төгрөгөөр буюу 17.6 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 801.4 мянган төгрөг буюу 0.7 хувиар өссөн, урсгал засварын зардал 9775.0 мянган төгрөг буюу 31 хувиар, томилолтын зардал 796.8 мянган төгрөг буюу 20.2 хувиар, урсгал шилжүүлэг 6389.5 мянган төгрөг буюу 66.1 хувиар буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бичилт байхгүй байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт:**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 704496.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 704496.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Гаалийн ерөнхий газраас тус байгууллагын төсвийг 704496.6 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

**Төсвийн гүйцэтгэл:**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 704496.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 698496.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 6000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр санхүүжилтийг улсын төсвийн санхүүжилтээр 698496,6 мянган төгрөг, өөрийн орлогоор 4092,3 мянган төгрөг авч, төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 2386,4 мянган төгрөгийг оны эцэст улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар Ховд аймгийн Булган дахь гаалийн газар нь тайлант онд 6000,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 4961,1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 1038.9 мянган төгрөгөөр биелүүлээгүй байна. Орлого төвлөрүүлэх төлөвлөгөө тасарсан шалтгаан нь туслах аж ахуйн орлого буурсантай холбоотой юм.

Хүснэгт 3 Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт /мян.төг/

| код | хөтөлбөр, арга хэмжээ | мөнгөн дүн |
|---|---|---|
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 1736.06 |
| 80103 | Гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ | 650,3 |
| | Нийт дүн | 2386.4 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт:**

Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар ямар нэгэн мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийгдээгүй байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлэн ажилласан байна.

## 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 7243.8 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллажээ.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мян.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Албан шаардлага | 0 | 0 | | 0 | 0 | 0 | 0 |
| Зөвлөмж | 2 | 7243.8 | 2 | 7243.8 | 0 | 0 | 100 |
| **Нийт дүн** | **2** | **7243.8** | **2** | **7243.8** | **0** | **0** | **100** |

## 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн алдаа зөрчилд давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

**<u>Залруулсан алдаа</u>:**

Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

**Аудитын зөвлөмж:** Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

# 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### *1. Программ хангамжийн ашиглалт*

*1.1.* *<u>Илрүүлэлт:</u>* Нягтлан бодох бүртгэлийн программын ашиглалтад нярав ашиглах эрх нээж өгч, нярвын үүргийг нэмэгдүүлж бараа материалын бүртгэлийг сайжруулах шаардлагатай байна.

*1.2.* *<u>Эрсдэл:</u>* Төсвийн хөрөнгийг үр өгөөж буурах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, бараа материал дутагдах

*1.3.* *<u>Өгсөн зөвлөмж</u>: Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийн ашиглалтыг сайжруулан эд хариуцагчийн эрхийг өгч нярвын тайланг программ хангамж ашиглан гаргах*

*1.4. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>* Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо: 2021

Аудитын нэр: ***Булган дахь гаалийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит***

Аудитын код: ХОА-2021/117/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр: **Булган дахь гаалийн газрын**

Мянган төгрөгөөр

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийн ашиглалтыг сайжруулан нярвын эрхийг нээн эд хариуцагчийн тайланг программ хангамжаар гаргаж хэвших | 0 | Зөвлөмж өгөх | Дарга, нягтлан бодогч | О.Лхагва-Эрдэнэ О.Пүрэвсүрэн |
| **ДҮН** | | **0** | | | |

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**